# “УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН” ОНӨТҮГ-ЫН
# 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

УЛААНБААТАР ХОТ
2023 ОН

**“УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН” ОНӨТҮГ-ЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 12 дугаар сарын 11 — Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (мян.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1.** Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Үндэсний агуулга бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ. /НЗДҮАХ 2.6/ | | | | | | | |
| 1 | **Зорилт 1.** Улаанбаатар хотын музейн барилгыг засварлаж үйл ажиллагааг боловсрол, түүх соёлын чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлнэ. /НЗДҮАХ-2.6.2.3/ | | | | | | |
| 1.1 | Музейн барилгыг түүхэн байгууламж хэлбэрээр сэргээн засварлах, өргөтгөлийн шинэ барилга барих санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ ажлын хүрээнд холбогдох бичиг баримтыг боловсруулна. | - | Хүргүүлсэн саналын тоо | 1 | 1 | Улаанбаатар хотын музей нь 2024 оны төлөвлөгөөний төсөлд тусгах төсөл, арга хэмжээний саналаа холбогдох шаардлагын дагуу боловсруулан 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 81 дугаар албан бичиг хүргүүлсэн.<br>-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр арга хэмжээтэй уялдуулан шинээр хэрэгжүүлэх шаардлагатай төслийн саналыг Олон улсын хамтын ажиллагааны агентлаг (КОИКА)-ийн төсөл боловсруулах загвар (PCP)-ын дагуу "Улаанбаатар хотын музейг сэргээн засварлах төсөл"-г боловсруулан НЗДТГ, НСУГ-т 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 79, 80 дугаар албан бичиг тус тус хүргүүлсэн.<br>-“Улаанбаатар хотын музейн барилгын урсгал засвар болон бие засах газрын нөхцөлийг сайжруулах ажил”-ыг төлөвлөж Нийслэлийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хөрөнгөөс (100 сая төгрөг) санхүүжихээр Нийслэлийн засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/1011 захирамж гарсан.<br>Зорилтын хүрээнд саналаа хүргүүлсээр байгаа хэдий ч төсөл батлагдаагүй л байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 2 | **Зорилт 2.** Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг оюуны өмч зохиогчийн эрх, инновацид тулгуурлан хөгжүүлнэ. /НЗДҮАХ-2.6.5/ | | | | | | |
| 2.1 | Музейн брэнд дүр “Хотудай”-г оюуны өмчид бүртгүүлэх ажлын хүрээнд мэдээллийг судлаж танилцуулах | - | Зохиогчийн эрхийн гэрчилгээ | - | 1 | Музейн дүр "Хотудай"-г Оюуны өмчид бүртгүүлэхэд шаардлагатай баримт мэдээллийг Оюуны өмчийн газраас судалж музейн удирдлага болон холбогдох ажилтнуудад танилцуулсан. “Хотудай” брэнд дүрийг Оюуны өмчид бүртгүүлэх материалыг бэлтгэх явцад музейгээс зураачтай хийсэн гэрээг нөхөн хийх талаар зураач А.Аззаятай холбогдсон гадаад явсан тул гэрээг шинэчлэн хийх боломжгүй болсон. Иймд энэхүү ажлыг 2024 онд хийхээр төлөвлөж байна.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 50% | 50 |
| **Зорилт 3. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** - Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ | | | | | | | |
| 3.1 | Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр өгөөжтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, санхүүгийн тайланг холбогдох байгууллагуудад хуулийн хугацаанд хүргүүлнэ. | - | Улирал бүр тайлан гаргаж хүргүүлсэн тоо | Сар бүр | Сар бүр | Музейн 2023 оны 6,7, 8 -р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, орлогын болон өр авлагын дэлгэрэнгүй мэдээ тайланг сар бүр гаргаж, Нийслэлийн Төрийн сангийн хэлтэст хүргэн, хянуулж баталгаажуулсан.<br>Батлагдсан төсөв: 3-р улиралд: 397,968.5 мян. төгрөг Үүнд:<br>1. Төсвөөс санхүүжих -395,133.5 мян.төгрөг<br>2. Үндсэн үйл ажиллагааны орлого- 2,835.0 мян.төгрөг<br>Гүйцэтгэл : 387,742.0 мян.төгрөг<br>1. Төсвөөс урсгал санхүүжилт – 386,348.5 мян.төгрөг<br>2. Үндсэн үйл ажиллагааны орлого- 1,393.5 мян.төгрөг<br>Нийт зарлагын дүн: 344,514.1 мян.төгрөг<br>1. Цалин хөлс болон нэмэгдэл урамшил – 275,789.6 мян.төгрөг<br>2. НДШ /АО/ -34,978.4 мян.төгрөг<br>3. Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал -5,608.9 мян.төгрөг<br>4. Хангамж, бараа материалын зардал - 6,550.8 мян.төгрөг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж -7,722.1 мян.төгрөг<br>6. Багаж техник хэрэгсэл – 1,300.0 мян.төг<br>7. Газрын төлбөр -290.6 мян. төгрөг<br>8. Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал – 10,437.7 мян.төгрөг<br>9. Нэг удаагийн мөнгөн тэтгэмж – 1,836.0<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.2 | Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ. | - | Баримтын тоо | 1 | 2 | Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2022 онд “Улаанбаатар хотын музейн барилгын засвар, техник хэрэгсэл нийлүүлэх тухай” 202202289 дугаартай тендер зарлагдаж “Онь тэнгэрийн бичиг ХХК” хөрөнгө тус бүрийн техник үзүүлэлт, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хянан шалгаж хүлээн авсан. 24 нэр төрлийн 78 ширхэг эд хөрөнгө нийлүүлэгдсэн бөгөөд музейн ажилтан тус бүрт хүлээлгэн өгч, бүртгэлийг хөтөлж баталгаажуулсан. Байгууллагын төвийн хөрөнгөөр шинээр худалдан авсан хөрөнгийг эд хариуцагч бүрийн картанд бүртгэж, баталгаажуулсан. Жилд 2 удаагийн эд хөрөнгийн тооллогоор бүртгэлийн хөтлөлт хийсэн байна.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.3 | Байгууллагын эд хөрөнгө болон тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ашиглалт хамгаалалтанд хяналт тавьж, эд хариуцагчийн бүртгэл, карт хөтлөх | - | Бүртгэлийг хөтөлсөн байх | - | 2 | Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2022 онд “Улаанбаатар хотын музейн барилгын засвар, техник хэрэгсэл нийлүүлэх тухай” 202202289 дугаартай тендер зарлагдаж “Онь тэнгэрийн бичиг ХХК” хөрөнгө тус бүрийн техник үзүүлэлт, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хянан шалгаж хүлээн авсан. 24 нэр төрлийн 78 ширхэг эд хөрөнгө нийлүүлэгдсэн бөгөөд музейн ажилтан тус бүрт хүлээлгэн өгч, бүртгэлийг хөтөлж баталгаажуулсан. Байгууллагын төвийн хөрөнгөөр шинээр худалдан авсан хөрөнгийг эд хариуцагч бүрийн картанд бүртгэж, баталгаажуулсан. Жилд 2 удаагийн эд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгийн тооллогоор бүртгэлийн хөтлөлт хийсэн байна.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.4 | Байгууллагад шинээр худалдаж авсан үндсэн хөрөнгө болон бараа материлаыг дансны ангиллын дагуу хаягжуулах, коджуулах ажлыг зохион байгуулах | - | Коджуулах хөрөнгийн тоо | | 24 | Байгууллагын эд хөрөнгийн дансанд бүртгэлтэй 2023 онд музейд шинээр худалдан авсан машин, тоног төхөөрөмжийн 4 нэр төрлийн 4 ширхэг 4,564,000 төгрөг, бараа материалын дансанд 8 нэр төрлийн 28 ширхэг 3,565,116 төгрөгийн, нийт 12 нэр төрлийн 32 ширхэг 8,129,116 төгрөгийн эд хөрөнгийг бүрэн хаягжуулсан.<br>Нийт 24 нэр төрлийн 78 ширхэг тоног төхөөрөмж, эд хогшил хүлээн авч бүртгэлжүүлэн ажилтан тус бүрт хүлээлгэн өгсөн.<br>дараах хөрөнгүүдийг хүлээн аваад байна.<br>Үүнд:<br>1.Суурин компьютер 9 - 1ком+1дэлгэц<br>2. Суурин компьютер i5 – 7 ком<br>3. Суурин компьютер i7 – 5 ком<br>4.Зөөврийн компьютер – 3 ширхэг<br>5.Өнгөт принтер – 2 ширхэг<br>6.Принтер хар – 3 ширхэг<br>7.Люминаторын машин – 1 ширхэг<br>8.Зөөврийн өсгөгч – 1 ширхэг<br>9.Бичгийн шүүгээ – 5 ширхэг<br>10.Бичгийн ширээ – 14 ширхэг<br>11.Шүүгээ – 7 ширхэг<br>12.Оффис сандал-14 ширхэг<br>13.Сан хөмрөгийн тавиур-шүүгээ – 3 ширхэг<br>14.Дрон – 1 ширхэг<br>15.Осмо камер – 1 ширхэг<br>16.Микрофон – 1 ком<br>17.Чихэвч – 1 ширхэг<br>18.Камерны гэрэл – 1 ширхэг<br>19.Камерны хөл – 1 ширхэг<br>20.Видео камер – 1 ширхэг<br>21.Утасны аппарат – 1 ширхэг<br>22.Архивын сейф-2 ширхэг<br>23.Фото сканер -1 ширхэг<br>24.Хальсны сканер - 1 ширхэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-202312.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.5 | Архив, албан хэрэг хөтлөлт, байгууллагын ажлын зохион байгуулалтыг хууль тогтоомж, стандарт, журам зааврын дагуу хөтлөн явуулна**.** | - | Үйл ажиллагаа ны хэрэгжилт | Зааврын дагуу хөтлөн явуулна | Зааврын дагуу хөтлөн явуулна | -Өссөн дүнгээр байгууллагад ирсэн бичиг нийт 151 байна. Судалж байгаа 6 бичиг байна. Гадны байгууллагаас ирсэн зөрчилтэй 1 бичиг буцаасан.<br>-Өссөн дүнгээр байгууллагад ирсэн бичиг нийт 181 байна. Судалж байгаа 3 бичиг байна. Хугацаа хоцорч шийдвэрлэсэн бичиг байхгүй.<br>-Өссөн дүнгээр байгууллагаас нийт 162 албан бичиг явуулсан байна. Буцсан, зөрчилтэй бичиг байхгүй. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр явсан бичгийг бүртгэж, хэвлэмэл хуудсанд буулгаж, дугаарлан албажуулсан байна.<br>-Өссөн дүнгээр тайлант хугацаанд нийт 64 тушаал гарсан. А тушаал 49, Б тушаал 15 гарсан.<br>- Захирлын дэргэдэх захиргааны зөвлөлийн 01-10 хурлын тэмдэглэл хөтлөж, хянуулан албажуулав.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.6 | Нийслэлийн архивд 2004-2022 оны байнгын хадгаламжийн нэгжийг шилжүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулна. | | Үйл ажиллагаа ны хэрэгжилт | Зааврын дагуу хөтлөн явуулна | Зааврын дагуу хөтлөн явуулна | НАГ-н нөхөн бүрдүүлэлтийн хуваарийн дагуу дараах материалуудыг зохих журмын дагуу боловсруулан хүлээлгэн өгсөн. Үүнд:<br>1.Байнга хадгалах хадгаламжийн нэгж 2014-2021 оны 194 хадгаламжийн нэгж<br>2.Захирамжлалын цахим бүртгэлийн 2014-2021 оны 1 хадгаламжийн нэгж<br>3.Цахим гэрэл зургийн хадгаламжийн нэгж 2009-2018 оны 1 хадгаламжийн нэгж<br>4.70 жил хадгалах хадгаламжийн нэгж 2002-2021 оны 76 хадгаламжийн нэгж<br>5.Түр хадгалах хадгаламжийн нэгж 2008-2021 оны 213 хадгаламжийн нэгжийн баримтын бүртгэл үйлдэж<br>6.2006-2020 оны Устгах 30 хэргийн 67 хадгаламжийн нэгжийг ялгаж устгахаар хэрэг бүрдүүлж дансны 9 бүрдэл, түүхчилсэн лавлах бичсэн.<br>-2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Нийслэлийн архивын газрын Мэргэжил арга зүйн хурлаар "Улаанбаатар хотын музей"-н архивын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | данс бүртгэл, жагсаалтыг хэлэлцсэн. Хурлаар гаргасан үүрэг даалгаврын хэрэгжилтийг ИЛТГЭХ ХУУДАС, АКТ-аар илгээсэн.<br>Дараагийн дээд шатны хурал 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдөр болж баталгаажуулав.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.7 | Дээд газрын тогтоол, шийдвэрээс өөрийн байгууллагад холбогдох заалтыг хяналтад авч, бүртгэл хяналтын карт хөтлөх, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжүүлсэн мэдээ тайланг сар, улирал, хагас жил, бүтэн жилээр гаргаж, үр дүнг байгууллагын удирдлага болон захирлын дэргэдэх зөвлөлд танилцуулна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт | Зааврын дагуу хөтлөн явуулна | Зааврын дагуу хөтлөн явуулна | -Байгууллагын үйл ажиллагаанд холбогдсон 2-хууль, 6-тогтоол, 6-захирамжийн биелэлтийн тайланг дээд шатны байгууллагад илгээсэн.<br>-1.Захирагчийн ажлын алба Захирамж 2023.03.24 дугаар 01/24<br>2.НЗД-ын захирамж 2023.03.16 А/194<br>3. НЗД-ын захирамж 2023.01..24 Б/12<br>4.МУЗГ-ын тогтоол 2023.01.11 Дугаар 15<br>Байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийн дагуу холбогдох захирамж, дээрх тогтоолыг хэрэгжилтийг ханган ажиласан.<br>-Музейн үйл ажиллагаанд мөрдөгддөг монгол улсын хууль, дүрэм, журмын эмхэтгэлийг шинэчлэн 2020-2023 онд батлагдсан хууль, журам, зааварыг нэмж хавсарган гарын авлага бэлтгэв.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.8 | Музейн ажилтнуудын ажлын чанар, хариуцлагыг дээшлүүлэх, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулна. | - | Зохион байгуулсан ажлын тоо | 4 | 4 | 2023 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө<br>2023 оны 1-р улирлын төлөвлөгөө<br>2023 оны 2-р улирлын төлөвлөгөө<br>2023 оны 3-р улирлын төлөвлөгөө<br>2023 оны 4-р улирлын төлөвлөгөө<br>2023 оын 1-р улирлын тайлан<br>2023 оын 2-р улирлын тайлан<br>2023 оын 3-р улирлын тайлан<br>2023 оын 4-р улирлын тайланг тус тус бүх албан хаагчдаас цаг хугацаанд нь хүлээн авч дүгнэв.<br>2023 оны 04 дүгээр сарыын 21 өдрийн музейн захирлын дэргэдэх захиргааны зөвлөлийн 03 хурлаар 1-р улирлын ажлын гүйцэтгэлийг дүгнэн хэлэлцүүлж батлуулав. 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн захирлын дэргэдэх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захиргааны зөвлөлийн 05 хурлаар хагас жилийн ажлын гүйцэтгэлийг дүгнэн хэлэлцүүлж батлуулав.<br>-Улаанбаатар хотын музейн ажилтан албан хаагчдын ажил дүгнэх, ур чадвар, үр дүнгийн нэмэгдэл олгох журмыг музейн захирлын 2023 оын 05 дугаар сарын 15-ны өдрийн А/17 дугаар тушаалаар батлав.<br>-2023 оны 06 дугаар сарын 19-ний А/25 дугаар тушаал үр дүнгийн урамшуулал<br>-2023 оын 07 дугаар сарын 05-ны өдрийн Б/10 тушаал ур чадварын нэмэгдэл<br>-Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 2-ны өдрийн 301 дүгээр тогтоол, ЗГХЭГ-ын даргын 98 дугаар тушаалын дагуу 2023 оны гүйцэтгэлийн тайланг албан хаагчидаас хүлээн авч нэгтгэн дүгнэх ажиллагаа хийгдэж байна. Үүний хүрээнд музейн захирлын тушаалаар үнэлгээний баг байгуулагдсан.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.9 | Байгуулагын улирал, хагас, бүтэн жилийн тайланг нэгтгэн гаргаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийж холбогдох байгуулагад хугацаанд нь хүргүүлнэ. | - | Нэгтгэн гаргах тайлангийн тоо | 4 | 4 | -Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хариуцлагын гэрээгээр баталгаажуулав.<br>-Байгууллагын 2023-2024 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж холбогдох дээд байгууллагад хугацаанд нь хүргүүлэв.<br>-Байгууллагын 2023 оны 1-р улирлын тайлан нэгтгэн гаргаж НЗДТГ, НСУГ-т хүргүүлэв<br>-Байгууллагын 2023 оны хагас жилийн тайлан нэгтгэн гаргаж НЗДТГ, НСУГ-т хүргүүлэв.<br>Байгууллагын 2023 оны жилийн эцсийн тайланг урьдчилсан байдлаар нэгтгэн гаргаж НЗДТГ, НСУГ-т хүргүүлэв.<br>-НЗДТГ-т 1-11 сар бүрийн хийж хэрэгжүүлсэн томоохон ажлын тайлан, төлөвлөгөөг холбогдох мэргэжилтэнд цаг хугацаанд нь хүргүүлсэн.<br>-НСУГ-т 1-11 сар бүрийн хийж хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайлан, тоон мэдээг маягтын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу боловсруулж холбогдох мэргэжилтэнд цаг хугацаанд нь хүргүүлсэн.<br>-НЗДТГ-ын Хяналт - Шинжилгээ, Үнэлгээний хэлтэст "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын төслийг холбогдох хууль, дүрэм журмын дагуу өөрийн байгууллагын онцлогт тохируулан боловсруулж илгээв. 2023.02.09<br>-НСУГ-т соёл, урлагийн байгууллагын хөрөнгө, санхүүгийн 2022 оны мэдээ нэгтгэн илгээв. 2023.04.11<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.06.31<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.10 | Улаанбаатар хотын музейн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн харилцаа, байгууллагын бүтцийн нэгж бүрийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж удирдлага болон холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулж шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний ажлын төлөвлөгөө гаргаж, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулна. | - | Дотоод хяналт шалгалт хийсэн тоо | 3 | 3 | 1.Улаанбаатар хотын музейн галын аюулгүй байдлын үзлэг, хяналт хийх тухай музейн захирлын тушаалаар комисс томилуулан үзлэг хяналт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар ажиллалаа.<br>Шалгалтаар цахилгааны утас ил байрласан, гал унтраах тоног төхөөрөмж дутмаг, галын дүгнэлт гаргаагүй зэрэг зөрчлүүд илэрснийг илтгэх хуудас бичин музейн удирдлагад танилцуулан музейн гадна сарай болон гал унтраах багаж хэрэгслийг шинэчлэн засварлаж, өрөөний цахилгааны утаснуудыг цэгцэлж утас дарагчаар даруулах зэрэг ажлууд хийгдээд байна.<br>2.Музейн бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагаанд үзлэг, шалгалт хийнэ.<br>- Музейн бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагаанд үзлэг, хяналт хийх тухай удирдамж боловсруулан, комисс томилж музейн захирлаар батлуулж<br>-Музейн бүртгэл мэдээллийн сангийн хяналт, шалгалтыг 6 төрлийн хууль, дүрэм, журам, стандартын 17 заалтаар дүгнэж ажиллав. Дотоод хяналт шалгалтын комисс бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагаанд өгсөн оноог харьцуулахад музейн үзмэрийн бүртгэл нь дүрэм журам, заавар, стандартын дагуу хийгдсэн ба 4.2 оноо буюу “хангалттай” үнэлгээ авлаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Санхүү, өмчийн бүртгэлд үзлэг шалгалт хийлээ. Өмч хамгаалах байнгийн зөвлөлийн үйл ажиллагаа, эд хөрөнгийн жилийн хагасын тооллого тайлантай танилцлаа.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.11 | Ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан, тайлагнана. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 1 | 1 | Ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр 2023 онд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулан хэрэгжүүлж байна. Гуравдугаар улиралд музейн байранд “Хөгжлийн бэрхшээл ба хүний ялгаатай байдал”, “Монгол хэл бичгийн ерөнхий ойлголт” сэдэвт 2 сургалтад нийт албан хаагчид, харъяа дээд байгууллага болон хамтын ажиллагаатай байгууллагаас зохион байгуулагдсан 6 удаагийн сургалт семинарт давхардсан тоогоор 24 албан хаагч хамрагдсан.<br>Тайлант хугацаанд өссөн дүнгээр музейн байранд 5 удаа мэргэжил арга зүйн сургалт зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 76 албан хаагч хамрагдсан. Харъяа дээд байгууллага болон хамтын ажиллагаатай байгууллагуудаас зохион байгуулагдсан нийт 24 удаагийн сургалт семинар, зөвлөгөөнд давхардсан тоогоор 62 албан хаагч хамрагдсан байна.<br>Музейн албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах чиглэлийн хүрээнд 9 ажил хэрэгжүүлж, нийт 20,615,284.00 төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:<br>1.Засгийн газрын 488, 241 дугаар тогтоолыг үндэслэн албан хаагчдийн цалинг 2 удаа шинэчлэн баталсан.<br>2.Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан “Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжлийн үнэмлэх олгох” төлбөртэй нэг сарын сургалтад 2 албан хаагч хамрагдсан.<br>3.Балансын урамшуулал 2 албан хаагчид олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4.Нэг албан хаагчид буцалтгүй тусламж олгосон.<br>5.16 албан хаагчийн 32 хүүхдэд бэлэг дурсгалын зүйл олгосон.<br>6.Албан хаагчдийн ажлын ачаалал, ажилласан жил, чанар үр дүнг үнэлэн ур чадварын нэмэгдлийг улирал бүр олгосон.<br>7.Ажилтнуудын эхний хагас жилийн ажлын чанар бүтээмж, үр дүнд үндэслэн үр дүнгийн урамшуулал олгосон.<br>8.ММНБИ-ээс зохион байгуулсан “Санхүүгийн ажилтанг чадавхжуулах мэргэжил олгох” төлбөртэй сургалтад 2 албан хаагч хамрагдсан.<br>9.Нийслэлийн 384 жилийн ойг тохиолдуулан Захирал П.Даваасүрэнг “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-оор, бүртгэл мэдээллийн санч Ч.Өсөхжаргалыг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар, Архивын ерөнхий газрын “Хүндэт Жуух бичиг”-ээр архив, бичиг хэргийн ажилтан Д.Гантулгыг, Соёлын ажилтны баярыг тохиолдуулан Соёлын яамны “Жуух бичиг”-ээр шагнуулахаар сан хөмрөгч Б.Төгсжаргал, жижүүр-сан техникч Ж.Хадбаатар нарыг шагнуулахаар холбогдох<br>баримт бичгүүдийг илгээсэн. Соёлын ажилтны “Алтан гарди” оны шилдэг тодруулах наадамд оны шилдэг санхүүчээр нягтлан бодогч Ж.Мөнхтуяа тодорсон. Холбогдох баримт бичгүүдийг илгээсэн.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.12 | Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих. | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | - | 1 | -Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “НОГООН ХОТ-ИРГЭНИЙ ОРОЛЦОО” аянд байгууллагын албан хаагчдын оролцоог хангаж, мод тарих, тарьц суулгацыг бэлтгэх ажлыг хариуцсан байгууллагатай холбогдон зохион байгуулж “Баянгол цэцэрглэгт хүрээлэн”-д хайлаас 10 ширхэг, шар хуайс 4 ширхэг нийт 14 мод худалдан авч тарих ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын улиралд тарьсан модны усалгаа арчилгааг 10-р сарын 6-ны өдөр хийж гүйцэтгэсэн.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 3.13 | Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах. | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | - | 1 | Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-аас Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2 цагийн сургалт музейн ажилтнуудад зохион байгууллаа.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 3.14 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах. | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | - | 1 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын хүрээнд Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан “Харилцан хүндэтгэе” аян болон жил бүрийн 11 сарын 25-наас 12 сарын 10 өдөр хүртэл зохион байгуулдаг Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд нэгдэж, аяны хүрээнд Хүчирхийллийн эсрэг үндэсний үндэсний төвийн ТББ-тай хамтран “Гэр бүл болон бэлгийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг нийт байгууллагын албан хаагчдын дунд зохион байгуулав. Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж ажилласан 2023 оны ажлын тайлангаа холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажиллав.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| **Зорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт –** Музейн зорилго, үйл ажиллагааны чиглэл /НИТХ Тэргүүлэгчдийн тогтоол дугаар 32/ | | | | | | | |
| 4.1 | **Улаанбаатар хотын түүхэн хөгжлийн явцад бий болсон биет соёлын өв, эд өлгийн зүйлийн хайгуул судалгааг хийж, сан хөмрөгийг баяжуулна. /УБХМД-4.2.1/** | | | | | | |
| 4.1.1 | Байгууллага, иргэдийн гар дээр байгаа үзмэр, эд өлгийн зүйлийн хайгуул, судалгаа хийж, бүртгэл хөтөлнө. | - | Бүртгэгдсэн үзмэр, эд өлгийн зүйлийн тоо | - | 5 | Эртний эдлэл цуглуулагч О.Маш-Эрдэнэтэй /91913234/ 06 дугаар сарын 22-нд уулзан Богд хаант Монгол Улс болон социализмын үеийн Улаанбаатар хотын нэгэн айлын аж байдлыг харуулах хос авдар, шогол, дөрвөн нүдтэй шүүгээ, жижиг ширээ, жижиг ширээ, тулга, тогоо, арслантай модон сав гэсэн 6 дэсийн 8 ширхэг эд өлгийн зүйл, Урлаг судлаач, цуглуулагч | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | С.Бадралтай 10 дугаар сарын 02-нд уулзаж, Их хүрээ, Нийслэл хүрээ, Социализмын үеийн холбогдолтой угсаатны зүйн төрлийн 13 дэсийн 14 ширхэг эд өлгийн зүйл, нийт 19 дэсийн 22 ширхэг эд өлгийн зүйлийн судалгаа хийж, худалдан авах үзмэр эд өлгийн зүйлийн бүртгэлд бүртгэн авсан.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.1.2 | Музейн сан хөмрөгийг Улаанбаатар хотын түүхэн хөгжлийн явцад бий болсон биет соёлын өв, эд өлгийн зүйлээр баяжуулна. | 18,500 Нийслэлийн төсөв | Баяжуулсан үзмэрийн тоо | - | 5 | -Музейн захирлын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/47 дугаар тушаалаар 9 дэсийн 10 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлээр сан хөмрөгт баяжилт хийх ажлыг зохион байгуулав. Өссөн дүнгээр нийт 21 дэсийн 62 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлээр сан хөмрөгийн баяжилтыг хийсэн. Баяжилт хийсэн үнийн дүн 9,600,000 төгрөг болсон байна.<br>- Музейд шинээр авсан үзмэр, эд өлгийн зүйлийн фото зургийг дизайнер С.Эрдэнэбат, бүртгэл мэдээллийн санч Ч.Өсөхжаргалтай хамтран 21 дэсийн 62 ширхэг үзмэрийн фото зургийг баримтжуулан авсан.<br>-2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 812 дэсийн 3502 үзмэртэй болсон байна.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.1.3 | Музейн сургалт сурталчилгаанд ашиглаж байсан эд өлгийн зүйлсийг сан хөмрөгийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үзмэрийн баяжуулалт хийнэ. | | Баяжуулсан үзмэрийн тоо | - | 15 | -Музейн сан хөмрөгийн зөвлөлийн хурлыг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хурлаар сургалт сурталчилгаа, аж ахуйд ашиглаж байсан гэрэл зураг, атлас, утасны аппарат, чемадон, гэрэл зургийн аппаратыг сан хөмрөгт авах талаар хэлэлцэж, музейн захирлын 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар 12 дэсийн 52 ширхэг үзмэрийг нийт 500,000 төгрөгийн бүртгэлийн үнэ тогтоож, сан хөмрөгийн үзмэрийн баяжилтыг хийсэн. | 100 |
| 4.2 | **Музейн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтын баталгаат орчин бүрдүүлж, үзмэрийг арчлан тордон, сэргээн засварлана. /УБХМД-4.2.2/** | | | | | | |
| 4.2.1 | Музейн сан хөмрөгийн үзмэрийн хадгалалтын | 8,000 | Үзмэрийн тоо | 80 | 150 | Соёлын биет өвийг хамгаалж эрсдэлээс сэргийлэх ажилд энэ жилийн санхүүжилт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нөхцөлийг сайжруулах, эрсдлээс хамгаалах ажлыг зохион байгуулна. | Нийслэлийн төсөв - | | | | 8,125,000 төгрөг төсөвт сууснаас 7,365,085 төгрөгийг зарцуулж 759,915 үлдсэн байна.<br>Музейн сан хөмрөгийн үзмэрийн хадгалалтын нөхцөлийг сайжруулж, эрсдэлээс хамгаалах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>1. Чийг дулаан, гэрэл хэмжигч олон үйлдэлт төхөөрөмж 880,000 төгрөгөөр худалдаж авав.<br>2. Үзмэрийн аюулгүй байдлыг хангаж туузан хаалт 2 ширхэгийг 440,000 төгрөгөөр худалдаж авсан.<br>3. Үзмэрийн онцлог байдлаас шалтгаалан үзмэр тус бүрт тохирсон уут, баглаа боодол, хөшиг хаалт оёход шаардагдах оёдлын машиныг 700,000 төгрөгөөр худалдаж авсан.<br>4. Хортон шавьж халдваргүйжүүлэлтийг 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр болон 10 сарын 12-ны өдөр 250 м кв өрөөнд 467,500 төгрөгөөр ариутгал хийв.<br>5. Музей болон сан хөмрөгийн цэвэрлэгээ үйлчилгээ, бараа материал бусад хэрэгсэлийн зардалд 690,000 төгрөг зарцуулав.<br>6. Үзүүллэгийн танхимд автомат хаалгыг мэргэжилийн байгууллага болох “ХААН ХӨШИГ” ХХК-аар 1,684,000 төгрөгөөр хийв.<br>7. Үзүүллэгийн танхим болон сан хөмрөгийн өрөөнд хуурайшилт ихтэй тул үзмэр байгаа орчныг стандартын дагуу чийгшлийн түвшинг нэмэгдүүлэхийн тулд нийт 20 ширхэг хуванцар савыг 81,585 төгрөгөөр худалдан авав.<br>8. Шаардагдах бичиг хэргийн зардалд 72,000 төгрөгийг зарцуулав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 9. Сан хөмрөгийн өрөөний болон үзүүллэгийн танхимын түлхүүр хүлээлцэхэд шаардагдах лацыг 100,000 төгрөгөөр худалдан авав.<br>10. Зөөврийн ижил хэмжээтэй 3 ширхэг шилэн хорго хийлгэхэд 2,250,000 төгрөг зарцуулав.<br>11. Жаазлаагүй 12 дэсийн 12 ширхэг үзмэрийг бэлтгэсэн жаазанд хийж хадгалалтын нөхцөлийг сайжруулав.<br>-4 дүгээр улиралд 16 дэсийн 51 ширхэг үзмэрт хадгалалтын сав, баглаа, боодол зэргийг хийж, өссөн дүнгээр нийт 68 дэсийн 156 ширхэг үзмэрийг эрсдлээс хамгаалах ажлыг хийж гүйцэтгэлээ.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.2.2 | Музейн сан хөмрөгийн өрөө болон үзүүллэгийн танхимын хадгалалтын орчин нөхцөлийг сайжруулах ажлыг зохион байгуулна. | | Хийгдэх ажил | 2 | 4 | Сан хөмрөгийн өрөөний хадгалалтын орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Үзмэрийн витрины 2 талын хаалтыг сантехникч Ж.Хадбаатар, мужаан Ч.Хишигдэлгэртэй хамтран хийж үзмэр унах эрсдлээс хамгаалах ажлыг хийв.<br>2. 2023 онд ОНӨТҮГ-аас нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар музейн албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж болох сан хөмрөгийн үзмэрийг хадгалах зориулалт бүхий 2 ширхэг шүүгээг нэмэлтээр сан хөмрөгийн өрөөнд тавив.<br>3. Музейн сан хөмрөгийн үзмэрийг найдвартай хадгалах, баталгаат орчин бүрдүүлэхэд зориулалт бүхий үзмэр тавих нэмэлт тавиурыг сантехникч Ж.Хадбаатар, мужаан Ч.Хишигдэлгэртэй хамтран хийж үзмэрийн орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. Соёлын яамнаас нэгдсэн журмаар бүх музейг камержуулах ажлын хүрээнд манай музейн сан хөмрөгийн өрөөнд нийт 3 камер, 2 ус мэдрэгч, 2 хөдөлгөөн мэдрэгч, 1 утаа мэдрэгч зэргийг "Бодь электроникс" ХХК-аар хийж гүйцэтгүүлэн сан хөмрөгийн өрөөний аюулгүй байдал, орчин нөхцөлийг сайжруулав.<br>5. Үзмэрийг унаж хагарах эрсдэлээс сэргийлж сан хөмрөг дэх шилэн тавиур дээр нэмэлт тавиурыг Сантехникч-жижүүр Ж.Хадбаатартай хамтран хийж үзмэрийн хадгалалтын орчин нөхцөлийг сайжруулав.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.2.3 | Музейн барилга, сан хөмрөг, үзмэрийн аюулгүй байдал болон музейн үйл ажиллагааны явцад хөтлөгдөх бүртгэлүүдэд тогтмол хяналт тавина. | - | Хяналт тавьсан тоо | - | 4 | 1.Музейн үйл ажиллагааны явцад хөтлөгдөх бүртгэлүүд болох<br>- Сан хөмрөг болон үзүүллэгийн танхимын чийг дулаан хэмжсэн бүртгэл<br>- Үзүүллэгийн танхимын үзмэрийн аюулгүй байдал, хоргоны лац бүртгэл<br>- Сан хөмрөгийн өрөөнд орсон гарсан хүмүүсийн бүртгэл<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.2.4 | Музейн үзмэрийг бүртгэн баримтжуулах зааврын дагуу музейн үзүүллэгийн танхимын үзмэрийн аюулгүй байдал, арчилгаа цэвэрлэгээ, орчны хэвийн байдлыг хангаж, тогтмол хяналт тавина. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт | Зааврын дагуу хөтлөн явуулна | Зааврын дагуу хөтлөн явуулна | - Үзүүллэгийн танхим дахь үзмэрт цэвэрлэгээ хийсэн бүртгэлд хуваарийн дагуу хяналт хийж, баталгаажуулж ажиллав.<br>2.Үзмэр хянагч Л.Одмаа ээлжийн амралт авах, амралт дуусч ажилдаа буцан ороход үзүүллэгийн танхим дахь үзмэрийг тайлбарлагч Д.Дэлгэрмөрөнд хүлээлгэн өгөх, буцааж хүлээн авахад хяналт тавин, үзмэрийн бүрэн бүтэн байдалд шалгалт хийж ажиллаа.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.5 | Музейн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсээр хянуулж, батлуулах ажлыг зохион байгуулна.<br>Цаашид музейн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг мөрдөн ажиллана. | - | Төлөвлөгөө боловсруулсан тоо | - | 1 | -“Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах” тухай ажлын төлөвлөгөө бичиж музейн захирлаар батлуулав.<br>- БЗД-ийн Онцгой байдлын хэлтэс, МҮМ-н мэргэжилтэнтэй уулзаж төлөвлөгөө боловсруулах мэргэжил, арга зүйн зөвлөгөө авав.<br>- Гамшгаас хамгаалах мэргэжлийн анги байгуулах тухай Музейн захирлын 2023 оны А/10 дугаар тушаал батлулав.<br>- Музейн дизайнераар “Гамшгийн үед хэрэглэх аврах гарцын схем” зуруулав.<br>- 35 хуудас бүхий “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” боловсруулан музейн захирал, БЗД-ийн гамшиг хариуцсан мэргэжилтнээр батлуулж музейн ажилтнуудад танилцуулан гарын үсэг зуруулав.<br>- 6 дугаар сарын 08-ны өдрийн музейн нийт албан хаагчид нийслэлийн нутаг дэвсгэрт гамшгийн үед түр цуглах байршил болох Монгол бөхийн өргөөний хойно түр цуглан болзошгүй гамшгаас хамгаалах, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг ханган ажиллаа.<br>-Шинээр тавьсан дохиоллын системийг схем зургуудын зарим зөрүүтэй хэсгийг шалган шинэчилж гамшгаас хамгаалах төлөвлөгөөний аврах гарцын схем хэсэгт дахин оруулж төлөвлөгөөнд тодотгол хийлээ.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.3 | **Үзмэр, эд зүйлийг бүртгэн баримтжуулах, үзлэг тооллого явуулах, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохих журмын дагуу хийж гүйцэтгэнэ. /УБХМД-4.2.3/** | | | | | | |
| 4.3.1 | Сан хөмрөгийн бүртгэн баримтжуулах зааврын дагуу RCH бүртгэлийн программд үзмэр, эд өлгийн зүйлийн мэдээллийг бүртгэн оруулах ажлыг зохион байгуулна. | - | Бүртгэлийн программд оруулсан үзмэрийн дэсийн тоо | 45 | 147 | Соёлыг өвийн бүртгэн баримтжуулах зааврын дагуу “RCH” программд 147 дэсийн 1814 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэн оруулсан. “RCH” программд өссөн дүнгээр нийт 791 дэсийн 3440 ширхэг үзмэр бүртгэгдсэн байна.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.2 | Музейн сан хөмрөгт шинээр авсан үзмэрийг “Музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэл”-ийн дэвтэрт бүртгэнэ. | - | Бүртгэсэн үзмэрийн тоо | 11 | 20 | Музейн сан хөмрөгт шинээр авсан 21 дэсийн 62 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг ерөнхий бүртгэлийн дэвтэрт бүртгэн баталгаажуулсан. Одоогийн байдлаар музейн ерөнхий бүртгэлийн дэвтэрт нийт 812 дэсийн 3502 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл бүртгэгдсэн байна.<br>Эхлэсэн, дуусан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.3.3 | Соёлын өвийн бүртгэлийн “Register”, “RCH” программд шинээр авсан үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэн баримтжуулах ажлыг хийнэ. | - | Программд оруулсан үзмэрийн тоо | 11 | 20 | Музейн захирлын 2023 оны А/11, А/47 дугаар тушаалаар үзмэрт авсан нийт 21 дэсийн 62 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэлийн “Register”, “RCH” программд шивж оруулсан. Өссөн дүнгээр музейн ерөнхий бүртгэлийн дэвтэр болон “Register” программд нийт 812 дэсийн 3502 ширхэг үзмэр, эд өлгийн зүйл бүртгэгдээд байна.<br>Эхлэсэн, дуусан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.3.4 | RCH программд оруулсан “Соёлын өвийн бүртгэлийн маягт №2”-оор бүртгэгдсэн музейн үзмэр, эд өлгийн зүйлийг цаасан хэлбэрээр гаргаж, төрөлжүүлэн хавтаслана. | - | Цаасан хэлбэрээр гаргасан үзмэрийн тоо | 200 | 200 | Уран зургийн төрлийн үзмэрээс 60 ширхэг, угсаатан зүйн төрлөөс 50 ширхэг, баримт бичгийн төрлөөс 50 ширхэг, сийлбэр, гар урлалын төрлийн 20 ширхэг, гэрэл зургийн төрлийн үзмэрээс 20 ширхэг, нийт 200 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг төрөлжүүлэн хавтаслах ажлыг хийлээ.<br>Эхлэсэн, дуусан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.3.5 | Музейн эрдэм шинжилгээний ажилтны бичсэн үзмэрийн тодорхойлолт, судалгаа, монгол бичиг болон гадаад хэлээр бичигдсэн үзмэрүүдийн хөрвүүлэг, орчуулгыг RCH программд оруулан үзмэрийн мэдээллийн баяжилтыг хийнэ. | | Мэдээллийн баяжилт хийсэн үзмэрийн тоо | 30 | 32 | Эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэнгээс үзмэрийн тодорхойлолт бичиж, түүхийн судалгаа хийсэн 20 ширхэг, монгол бичиг болон гадаад хэлээр бичигдсэн үзмэрүүдийн хөрвүүлэг, орчуулга хийгдсэн 12 ширхэг, арга зүйч Б.Өлзийбаяраас 3 ширхэг үзмэрийн судалгаа хийсэн материалыг хүлээн авсан. RCH программд 35 үзмэрийн мэдээллийн нэмэлт баяжилтыг хийсэн.<br>-Музейд хадгалагдаж буй УБМ74.2 хувийн дугаартай С.Сэнгээ “Түүхт Улаанбаатар” - зааны ясан сийлбэрийн ерөнхий судалгаа хийж, музейн бүртгэлийн хуучин баримт бичгүүдийг шүүх, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | номын сангаас холбогдолтой материал шүүх, уран бүтээлчийн тухай нэвтрүүлэг үзэж, Соёлын Өвийн төвд сэргээн засварлуулсан үзмэрийн жагсаалтыг хүлээн авч судаллаа.<br>Дараах 3 үзмэрийг музейд үзмэр болж орж ирсэн товч түүх, үнийн мэдээлэл зэргийг музейн үзмэрийн хуучин гар карт, холбогдох баримт материалыг шүүж RCH программд нөхөн орууллаа. (БМсанчийн хамтаар)<br>1. УБМ74.2 хувийн дугаартай С.Сэнгээ “Түүхт Улаанбаатар” - зааны ясан сийлбэр<br>2. УБМ77.1хувийн дугаартай С.Сэнгээ “Ясан хөөрөг”<br>3. УБМ76.4 хувийн дугаартай С.Сэнгээ “Орос монгол цэрэг” - ясан сийлбэр<br><br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.4 | **Музейн үндсэн чиглэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж, үзүүллэгийг Улаанбаатар хотын түүхийн судалгааны сүүлийн үеийн үзэл баримтлал, ололтод тулгуурлан, шинэлэг шийдэл, зохимжтойгоор дэглэн нийтийн хүртээл болгоно. /УБХМД-4.2.4/** | | | | | | |
| 4.4.1 | Сан хөмрөгийн үзмэрийн сэдэвчилсэн болон түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой түр, явуулын үзэсгэлэн гаргаж, нийтийн хүртээл болгон сурталчлах ажлыг зохион байгуулна. | - | Үзэсгэлэн гаргасан тоо | 4 | 5 | 1.Сан хөмрөгийн сэдэвчилсэн болон түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой түр, явуулын нийт 9 удаагийн үзэсгэлэнг байнга зохион байгуулж 12352 хүнд музейн үйлчилгээг үзүүлж ажилласан байна.<br>Музейгээр:<br>2023 оны том хүн 1299, оюутан 683, гадаад хүн 88, хүүхэд 1427 нийт 3497 хүн үйлчлүүлсэн.<br>• "Музей үзэх гоё" сэдэвт музейн нээлттэй өдөрт “Өргөөгөөс-социалист улаанбаатар” үзэсгэлэн<br>• Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадамд зориулсан “Ардын хувьсгал” уран зураг, макет, баримт бичгээс бүрдсэн үзэсгэлэн<br>• Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 384 жилийн ой, Улс тунхагласны 99 жилийн ойд зориулсан "ОСКАР МАМЕНЫ ЕРТӨНЦ ба МОНГОЛЧУУД ЦАМ ба | 100 |

МАЙДАР" сэдэвт үзэсгэлэн

Арга хэмжээ, явуулын үзэсгэлэнгээр:

| Д/Д | Үзэсгэлэнгийн нэрс | Хаана Хэзээ | Том хүн | Хүүхэд | Х/Б иргэн | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | “Улаанбаатарын хаврын баяр 2023” нээлттэй өдөрлөг | Сүхбаатарын талбайд 2023.04.14-15 | 4350 | 2450 | | 6800 |
| 2. | “Улаанбаатар - Олон улсын хөрөнгө оруулалт, түншлэлийн форум” | НЗДТГазар Хангарьд - 2 2023.04.20 | 400 | | | 400 |
| 3. | “Хүний хөгжил – нийгмийн хөгжил” нийгмийн салбарын нэгдсэн өдөрлөг "Өөрчлөгдөж буй Улаанбаатар" гэрэл зургийн үзэсгэлэн | Сүхбаатарын талбайд 2023.04.26-27 | 337 | 35 | | 372 |
| 4. | “Соёлын сэргэлт 2023” аян "Өөрчлөгдөж буй Улаанбаатар" гэрэл зургийн үзэсгэлэн | Баянзүрх, Налайх, Багануур, Багахангай дүүргийн Соёлын ордноудад 2023.05-06 сар | 632 | 398 | | 1030 |
| 5. | "Өөрчлөгдөж буй Улаанбаатар" гэрэл зургийн үзэсгэлэн | Ерөнхий боловсролын 25 дугаар тусгай сургууль. 2023.10.23 | | | 100 хүүхэд | 100 |

Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11

Биелэлтийн хувь: 100%

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>
<table>
<tr><td>6.</td><td>“Соёлын бүтээлч сар” аян "Өөрчлөгдөж буй Улаанбаатар" гэрэл зургийн үзэсгэлэн</td><td>Улаанбаатар Хотын нийтийн номын сан 2023.11.17-26</td><td>52</td><td>101</td><td></td><td>153</td></tr>
<tr><td></td><td>Нийт дүн</td><td></td><td>5771</td><td>2984</td><td>100</td><td>8855</td></tr>
</table>
</td><td></td></tr>
<tr><td>4.4.2</td><td>Музейн хаяг тайлбар бичих журмыг арга зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, батлуулна.</td><td>-</td><td>Батлуулсан журмын тоо</td><td>-</td><td>1</td><td>-06 дугаар сарын 25-нд Улаанбаатар хотын музейн байнгын үзүүллэг болон түр үзэсгэлэнгийн хаяг, тайлбар бичих журмыг бичин арга зүйн зөвлөлийн хурлаар батлуулсан.<br>-06 дугаар сарын 25-нд Улаанбаатар хотын музейн байнгын үзүүллэг болон түр үзэсгэлэнгийн хаяг, тайлбар бичих журмыг арга зүйн зөвлөлийн хурлаар батлуулж, 2023 оны 08 дугаар сарын 03-нд музейн танхимын 69 үзмэрийн тайлбарыг хаяг, тайлбар бичих журмын дагуу бүрэн шинэчилсэн.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100%</td><td>100</td></tr>
<tr><td>4.4.3</td><td>Музейн арга зүйн зөвлөлийн хурлыг зохион байгуулж, музейн үндсэн үйл ажиллагааны холбогдолтой асуудлуудыг хэлэлцүүлнэ</td><td>-</td><td>Зөвлөлийн хуралдсан тоо</td><td>2</td><td>2</td><td>Музейн хаяг тайлбар бичих журмын төслийг эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэн боловсруулан арга зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн ба арга зүйч журмыг бусад музейн журам болон зарим мэдээлэлд судалгаа хийн, өөрчлөлт оруулж 2 удаа хэлэлцэн арга зүйн зөвлөлөөр баталлаа.<br>1.Музейн сан хөмрөгийн хамдгалалт хамгаалалтын байдалд үзлэг явуулах тухай удирдамж боловсруулан музейн захирлаар батлуулж, 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр арга зүйч Б.Өлзийбаяр, эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр, бүртгэл мэдээллийн санч Ч.Өсөхжаргал нарын бүрэлдэхүүнтэй музейн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын байдалд үзлэг, шалгалт хийх ажлыг зохион байгууллаа. Энэхүү үзлэг шалгалтаар сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд эрсдэл үүсч болзошгүй зөрчлүүд илэрсэн ба илтгэх хуудас бичиж музейн захиралд танилцууллаа.</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Мөн 2022 оны музейн сан хөмрөгийн хадгалалт, хамгаалалтын үзлэгээр илэрсэн зөрчлийг хэрхэн арилгасан тухай үзлэг шалгалтыг давхар хийлээ.<br>3. Арга зүйн зөвлөлөөр Урлаг судлаач С.Бадралаас музейд худалдан авч буй 9 дэсийн 10 ширхэг эд зүйлийн тодорхойлолтод арга зүйн зөвлөлийн гишүүдийн оруулсан саналуудыг тусган гишүүдийн 100%-ийн саналаар зүйлийн тодорхойлолтыг батласан. Батлагдсан үзмэрийн тодорхойлолтыг Үзмэрийн ерөнхий бүртгэлийн (1110UBM0004) дэвтэрт бүртгэхийг бүртгэл мэдээллийн санч Ч.Өсөхжаргалд хариуцахаар болов.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.5 | **Музей судлал, сан хөмрөгийн үзмэр, Улаанбаатар хотын хөгжлийн түүхийн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулна. /УБХМД-4.2.5/** | | | | | | |
| 4.5.1 | “Улаанбаатар мэдээ” сонины 1955-1990 оны дугаараас хотын удирдлага зохион байгуулалт, засаг захиргаатай холбогдолтой илтгэл, нийтлэлийг шүүн авч, баримтын эмхэтгэл гаргах ажлыг зохион байгуулна. | 15,000 Нийслэлийн төсөв | Хэвлүүлсэн номын тоо | - | 100 | Улаанбаатарын мэдээ сонины хотын удирдлага зохион байгуулалт, засаг захиргаатай холбогдолтой илтгэл, нийтлэлийг бүрэн шүүж дууссан ба нийтлэлийг шивж цахим хэлбэрт оруулах ажлыг хийж байна. 2023 онд уг нийтлэлүүдээр эмхэтгэл хэвлүүлэх гаргах байсан ч Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу “Монгол Улс нийслэл Улаанбаатар он дараалын бичиг” номын судалгааны ажлыг хийснээс шалтгаалж дээрх эмхэтгэлийг хэвлэлд бэлтгэх ажилд нөлөөлж, уг ажил удааширсан. 2022 онд 25 ширхэг хэвлүүлсэн “Улаанбаатарын мэдээ сонинд хэвлэгдсэн хотын түүхтэй холбогдох нийтлэлийн эмхэтгэл” нэгдүгээр боть номд нэмэлт өөрчлөлт оруулж оны өмнө 300 хувь хэвлүүлэхээр бэлтгэл ажлыг зохион байгуулж байна.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-202312.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.5.2 | “Улаанбаатар хотын түүхийн чиглэлээр судалгаа хийж, | - | Хэвлүүлсэн өгүүлэл, | - | 2 | -Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй “Жинхэнэ харьяатын үнэмлэх” | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл бичиж хэвлүүлнэ. | | нийтлэлийн тоо | | | үзмэрийн судалгааг хийн, нийтлэл бичин музейн албан ёсны хуудсан нийтлэхээр бэлтгэж байна.<br>-Чингис хаан музейд болсон "Архангай 100: Эртний төрт улсуудын өлгий нутаг" эрдэм шинжилгээний хуралд "Архангай аймгийн нутагт Их хүрээ суурьшиж байсан мэдээ баримт" сэдэвт илтгэл тавьж, хэлэлцүүлсэн бөгөөд илтгэлийн эмхэтгэл 8 дугаар сард хэвлэгдэн гарсан.<br>Соёлын өртөө сэтгүүлд “Хүслийн мод буюу Гунгаачойлин дацангийн барилгаас үлдсэн багана” нийтлэлийг гэрэл зургийн хамт хэвлүүлэв.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.5.3 | “Монгол Арт” галарейтэй хамтран “Хүрээ хийдийн монгол зураг” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, “1870-аад оны Их хүрээ хотын монгол зураг” номын судалгааны ажлыг хийнэ. | | Судалгааны бичвэрийн хуудасны тоо | 60 | 80 | Төсөлт судалгааны ажлын хүрээнд Их хүрээний бүтэц, зохион байгуулалтын нэгж хэсгүүдийн түүхийг бичих ажлыг эхлүүлж, Зүүн хүрээ, Гандантэгчилэн, Маймаа хот, Баруун дамнуурчин, Орос хороолол буюу Консулын дэнж, Дамбадаржаа хийд, Даяны хүрээ буюу Шаддублин хийд, Буян-Ерөөлтийн сүм буюу Дашчойнхорлин, Худалдааны их зээл гэсэн Их хүрээний бүтцийн түүхийг бичиж дуусгав.<br>Нийт 85 хуудас судалгааны бичвэр бичив.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.5.**4** | “Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын түүх, хадгалалт хамгаалалт” номын судалгааны ажлыг хийж дуусган, хэвлэлийн эхийг бэлтгэнэ. | - | Судалгаа хийсэн дурсгалын тоо | - | 140 | Улаанбаатар хотын түүх, соёлын үл хөдлөх дурсгалын түүхийг судалж, нэгэн сэдэвт бүтээл хэвлүүлэх зорилтын хүрээнд хотын нутаг дэвсгэр дэх сүм хийд, дурсгалт барилга, хөшөө баримал гэсэн 3 төрлийн 153 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын он цагийг тодруулах, нягтлах, харьцуулах, баталгаатай эх сурвалжаас эрэн хайх судалгааны ажлыг хийж гүйцэтгэв.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2023.01.01-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.5.5 | Гоожингийн өндөр” хэмээн нэрлэгдэж буй түүхэн дурсгалт барилгын түүхийн судалгаа | - | Хэвлүүлсэн судалгааны | - | 1 | “Гоожингийн өндөр” хэмээх түүхэн дурсгалт барилгын нэрлэгдэж ирсэн нэр, баригдсан он цаг, байрлаж байсан хувь хүн, байгууллагын түүхийг тодруулах нарийвчилсан судалгаа хийж, өгүүлэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж, архивын баримт материал цуглуулна. | | өгүүллийн тоо | | | бичин ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Түүхийн судлал” сэтгүүлд хэвлүүлэхээр хүлээлгэн өгсөн.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2023.01.01-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.5.6 | “Улаанбаатар хотын түүх судлалын баримт, мэдээллийн сан”-г баяжуулах ажлыг зохион байгуулна. | | Баяжуулсан баримтын тоо | 250 | 10 | “Гоожингийн өндөр” хэмээх түүхэн дурсгалт барилгын нэрлэгдэж ирсэн нэр, баригдсан он цаг, байрлаж байсан хувь хүн, байгууллагын түүхийг тодруулах нарийвчилсан судалгааг архивын баримт, судалгааны ном зохиолд үндэслэн хийж, өгүүлэл бичин ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг “Түүхийн судлал” сэтгүүлд хэвлүүлэхээр хүлээлгэн өгсөн.<br>Үндэсний номын сангийн сан хөмрөгөөс “Улаанбаатарын мэдээ” сонины 1955-1990 оны 257 дугаарын 1684 нүүр бүхий 8GB хэмжээтэй баримтыг худалдан авч, хотын түүх, судлалын баримт, мэдээллийн санг баяжуулав.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.5.7 | Иргэдээс хотын тухай дурсамж сурвалжлан авч, нийслэлийн дурсамжийн санг баяжуулна. | | Баяжуулсан дурсамжийн тоо | 5 | 8 | Иргэдээс хотын аман түүх-дурсамж сурвалжлан авах ажлын хүрээнд Улаанбаатар хотын унаган иргэн, ахмад тээвэрчин Батсүхийн Ганбат, ахмад гэрэл зурагчин Л.Санжмятав, архитектор Ж.Баясгалан, газарзүйч О.Сүхбаатар, архитектор С.Одон, сэтгүүлч Ц.Хатанбаатар, барималч Б.Хийморь, цуглуулагч О.Батсайхан гэсэн 8 иргэнээс ярилцлага авч, “Нийслэлийн дурсамж”-ийн санг баяжуулав.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.5.8 | Музейн үзмэрүүдэд тодорхойлолт бичиж, үзмэрийн түүхийн судалгааг хийнэ. | - | Судалгаа хийсэн үзмэрийн тоо | - | 20 | 2023 онд Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй<br>1. Цацал (UBM08.9)<br>2. Тулга (UBM08.10)<br>3. Чөдөр (UBM08.11)<br>4. Үнсэн самбар (UBM09.7)<br>5. УБ хотын 370 жилийн ойн хүндэт медаль (UBM09.19) | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6. УБ хотын 370 жилийн ойн медалион (UBM09.20)<br>7. Нийслэлийн Засаг даргын “Хүндэт үнэмлэх” (UBM10.03)<br>8. Нийслэлийн Засаг Даргын дэргэдэх зөвлөлийн хурлын хавтас (UBM10.04)<br>9. Вьетнам автомат буу хонгионы хамт (UBM89.7-2)<br>10. Чернышевскийн барельеф (UBM89.15)<br>11. Ширээний целлойдон хэрэглэл (UBM89.29)<br>12. Варшав хотын эмблем /хөшөө/<br>13. Варшав хотын эмблем /хөөмөл/ (UBM89.30)<br>14. Новосибирск 1983 /хөөмөл/ (UBM89.31)<br>15. Верховный совет СССР медалион (UBM89.34)<br>16. Улаан сахиус (UBM08.14)<br>17. Сүм дуганы байршлын схем (UBM64.9)<br>18. Д.Сүхбаатарын, Д.Догсом нар гол дээр (UBM61.76)<br>19. Харчуудын хашаа (UBM69.6)<br>20. Хүрээний анхны байшин (UBM84.56)<br>гэсэн 20 үзмэрт тодорхойлолт бичиж, үзмэрийн түүхийн судалгааг хийн баримтуудыг бүртгэл мэдээллийн санчид хүлээлгэн өгсөн.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2023.01.01-12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.5.9 | Музейн сан хөмрөгт буй монгол бичиг болон гадаад хэлээр бичигдсэн үзмэрүүдийг хөрвүүлж, орчуулна. | - | Хөрвүүлж, орчуулсан үзмэрийн тоо | - | 12 | 2023 онд Улаанбаатар хотын музейн сан хөмрөгт хадгалагдаж буй<br>1. Автобус явуулах тухай бичиг (UBM61.41)<br>2. Жамъяан гүний хүү Дугарсүрэнг зэрэг залгамжлуулахыг хүссэн бичиг (UBM56.22)<br>3. Шанзавын эрхийг өргөсөн бичиг (UBM84.5) | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 4. Мөнгө хүүлэгч бичиг (UBM61.42)<br>5. Айлтгасан нь (UBM57.23)<br>6. Богдын зардлын бичиг (UBM61.55)<br>7. Жолоочийн үнэмлэх (UBM61.66)<br>8. Нийслэл хүрээний сонин бичгийн тасархай (UBM70.11)<br>9. Вьетнам автомат буу хонгионы хамт (UBM89.7-2)<br>10. Лениний зурагтай ваар (UBM89.11)<br>11. Дурсгалын далбаа туг дарцаг (UBM89.36-10)<br>12. Улаанбаатар хотын хятад ажилчдын клубийн гишүүний бат илэрхийлэх бичиг (УБМ12.1.5)<br>гэсэн 12 үзмэрийг орчуулж, хөрвүүлэн баримтуудыг бүртгэл мэдээллийн санчид хүлээлгэн өгсөн.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.5.10 | Музейн сан хөмрөг, үзүүллэгийн танхим дахь чийг, дулааны хэмжилтэд дүн шинжилгээ, судалгаа хийнэ. | - | Судалгаан ы тоо | | 2 | | 1. Музейн сан хөмрөгийн өрөөний чийг, дулааныг бүтэн жилийн турш хэмжилтийг хийсэн. Хийсэн хэмжилтэндээ дүн шинжилгээ хийж, боловсруулан холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажиллав.<br>2. Музейн үзүүллэгийн танхимын чийг, дулааныг бүтэн жилийн турш хэмжилтийг хийсэн. Хийсэн хэмжилтэндээ дүн шинжилгээ хийж, боловсруулан холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажиллав.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.5.11 | Музейн үзүүллэгийн танхимд дэглэгдсэн “Модон сийлбэр” төрлийн үзмэрүүдэд анхан шатны судалгаа хийнэ. | - | Судалгаан ы тоо | - | 1 | | Музейн үзүүллэгийн II танхимд дэглэгдсэн “Яндангийн цуурай”, “Гобелен”, “Тэнгэрийн багана”, “Модон сийлбэр” зэрэг үзмэрт анхан шатны судалгаа хийв. Бүртгэлд өгөх<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11 | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Биелэлтийн хувь: 80% | |
| 4.5.12 | Музейн үзмэрийн төрөл зүйл, бүтцэд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тоон үзүүлэлтийг гаргана. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | - | 1 | 1) Музейн сан хөмрөгийн үзмэрийг 6 төрөл зүйлд хуваан тоон үзүүллэлтийг гаргасан. Үүнд:<br>Археологийн дурсгал 12 дэсийн 28 ширхэг байгаа бөгөөд нийт үзмэрийн 0,81%<br>Түүхийн холбогдолтой цуглуулга 391 дэсийн 2852 ширхэг бөгөөд нийт үзмэрийн 81,68%<br>Угсаатан зүйн үзмэр нь 86 дэсийн 143 ширхэг бөгөөд нийт үзмэрийн 4,1%<br>Шашин шүтлэгийн холбогдолтой үзмэр нь 16 дэсийн 39 ширхэг байгаа бөгөөд нийт үзмэрийн 1,12%<br>Урлаг, уран сайхны холбогдолтой үзмэр нь 278 дэсийн 407 ширхэг бөгөөд нийт үзмэрийн 11.66%<br>Байгалийн түүхийн холбогдолтой үзмэр нь 20 дэсийн 23 ширхэг бөгөөд нийт үзмэрийн 0,58 %-ийг тус тус эзлэж байна.<br>2)Мөн музейн сан хөмрөгөөс түүхийн холбогдолтой 391 дэсийн 2852 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлийг 10 төрөл зүйлд хуваан тоон үзүүллэлтийг гаргасан. Үүнд:<br>1.Түүхэн бие хүний холбогдолтой эд өлгийн зүйл 9 дэсийн 50 ширхэг бөгөөд 1,7%<br>2.Бичгийн дурсгал 116 дэсийн 178 ширхэг бөгөөд 6,3%<br>3.Ном хэвлэл бичгийн дурсгал 8 дэсийн 8 ширхэг 0,3%<br>4.Зоос, мөнгөн тэмдэгт 33 дэсийн 224 ширхэг 7,9%<br>5.Бэлгэдэл, таних тэмдгийн холбогдолтой эд өлгийн зүйл 15 дэсийн 18 ширхэг 0,6%<br>6.Цэрэг байлдааны холбогдолтой эд өлгийн зүйл 0 дэсийн 0 ширхэг 0%<br>7.Үйлдвэрлэл бүтээгдэхүүн холбогдолтой эд зүйл 6 дэсийн 6 ширхэг 0,2%<br>8.Бэлэг дурсгалийн зүйл 43 дэсийн 62 ширхэг 2,2%<br>9.Гэрэл зураг төрөл 153 дэсийн 2298 ширхэг 80,5% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 10.Бусад төрлийн эд зүйл 8 дэсийн 8 ширхэг 0,3% - ийг тус тус эзлэж байна.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.5.13 | Музейн сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт, зөөж тээвэрлэхэд шаардлагатай материал, сав, баглаа, боодол, тоног төхөөрөмжийн судалгаа хийж, жагсаалт гарган музейн захирлаар батлуулж хуваарийн дагуу шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авна. | - | Судалгаа хийсэн тоо | - | 1 | Музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтад шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалын харьцуулсан судалгаа хийж 8,125,000 төгрөгийн үнэ бүхий 11 төрлийн тоног төхөөрөмж, бараа материалын зардлын төсөв гаргаж музейн захирлаар батлуулж дараах тушаалын төсөл боловсруулан дараах төхөөрөмжийг худалдан авсан. (Сан хөмрөгчийн хамтаар)<br>1.Чийг, дулаан, гэрэл хэмжигч олон үйлдэлт төхөөрөмж – 1ш<br>2.Метал хөлтэй туузан хаалт-2ш<br>3. Музейн үзүүлллэгийн танхимд Хан Түшиг ХХК-тай байгуулсан гэрээний дагуу автомат удирдлагатай хаалга суурилуулуулж хүлээн авлаа. Жич: Музейн үзүүлллэгийн танхим нь хаалгагүй онгорхой тул танхимын үзмэрийг хүлээлцэх боломжгүй, ажлын бус цагаар нээлттэй байгаа нь үзмэрт эрсдэлтэй байсан.<br>4.Үзэсгэлэнд ашиглах зөөврийн шилэн хоргоны загвар, материалын судалгаа хийж, загвар зураг гарган, гэрээ, тушаалын төсөл бэлдэн 3 ш шилэн хорго Тод дөхөм ХХК.д захиаллаа. 2. Үзүүллэгийн танхимд чийгшил өгөх зориулалтаар өргөн амсартай, хуванцар сав 15ш-ийг авлаа.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.6 | **Хүүхэд, залуус, иргэдэд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах, нийслэл хотоороо бахархах үзэл санааг төлөвшүүлэхэд чиглэсэн ажлыг зохион байгуулна. /УБХМД-4.2.6/** | | | | | | |
| 4.6.1 | Иргэдийг соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг мэргэжилтнүүдтэй хамтран үе шаттайгаар зохион байгуулна. | - | Хамруулсан иргэдийн тоо | 150 | 200 | 2023 оны 1 дүгээр сарын 07-ны өдөр “Иргэдийг соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-г гаргаж батлуулав.<br>2023 онд 5 сэдвийн хүрээнд 18 удаагийн боловсролын ажил зохион байгуулж нийт 1520 хүүхэд, залуусыг хамруулсан.<br>• “Нийслэл хүрээ” | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • “Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал“<br>• “Улаанбаатарын хог хаягдал”,<br>• "Миний төсөөллийн Улаанбаатар" сэдэвт боловсролын ажлууд<br>• "Утаагүй тамхи мода биш“ , “Улаанбаатар хотын түүхэн хөгжил” сэдэвт лекц<br>Нийслэлийн хүүхэд залуучуудын тусгай цогцолбор, 84, 21, 23, 124, 105, Эрхэм баян эрдэм, Оюунлаг, Арвис, Global, Оргил зэрэг ерөнхий боловсролын сургуулиуд , 122, 127 цэцэрлэг, МУИС, СЭЗДС-уудтай хамтран ажиллаж сургуулийн өмнөх болон сургуулийн нас, оюутан залуус хүүхдүүдэд соён гэгээрүүлэх боловсролын ажлыг хийж ажиллав.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.6.2 | Музейн боловсролын ажлын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ**.** | 4,000 Нийслэлийн төсөв | 1) хөтөлбөрийн тоо<br>2) иргэдийн тоо | - | 1) 4<br>2) 300 | Музейн боловсролын ажлын дараахь дэд хөтөлбөрүүдийг зохион байгуулж ажиллав.<br>• "Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал" /Lego/,<br>• "Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал" /Баримал/,<br>• “Нийслэл хүрээ”,<br>• “Богдын хүрээ”<br>Тайлант хугацаанд нийт 1520 хүүхэд залууст боловсролын ажил явуулсан.<br>-2023 оны 07 дугаар сарын 04 өдрийн 07 гэрээгээр “Улаанбаатар хотын музейн” барилгын эх хэв, силикон хэвийн Энпринт компанитай гэрээ байгуулан 2,800,000 хийлгэсэн.<br>2023 оны 07 сарын 06 өдөр “Нийслэлийн хүүхэд залуучуудын тусгай цогцолбор”-ын Урьханд байрлах зусланд очиж боловсролын ажилд шаардагдах бичиг хэргийн зардал 100,000.<br>2023 оны 09 сарын 23 “Автомашингүй өдөр” нэгдсэн арга хэмжээний үед боловсролын ажлын явуулах хэрэглэгдэхүүний зардал 1,595,000 төгрөгийг тус тус зарцуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Боловсролын дэд хөтөлбөр зохион байгуулахад нийт 4,495,000 төгрөг зарцуулсан.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.6.3 | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийслэлийн түүхэн дурсгалт газар, барилга байгууламж, хөшөө дурсгал, гудамж талбайг нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулна. | - | Сурталчилсан дурсгалын тоо | 35 | 20 | Монгол ТВ-д Нийслэл хүрээ, Социалист Улаанбаатар хотын 8 түүх, архитектурын дурсгалын хадгалалт хамгаалалтын талаар 2 удаа, Time.mn сайт МУИС-ийн барилгууд болон хотын түүх, ой санамж, хот байгуулалтын талаар 2 удаа, TV8 телевизэд Д.Манибадарын Нийслэл хүрээ зураг, Музейн барилгын түүх, Төв талбайн түүх, түүнийг тойрсон неоклассик, модернист 16 барилга болон Улсын драмын эрдмийн театрын барилгын талаар 3 удаа, Соёлын өртөө сэтгүүлд Гандангийн Хүслийн модын талаар нийтлэл, Цэгц студээс хийж буй “Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн” сэдэвт баримтат нэвтрүүлэгт Богдын хүрээ, Социалист Улаанбаатар, 1990 оны дараах Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөн, төвлөрлийн онцлог, хот байгуулалтын талаар 2 удаа, Focus.mn сайтад Музейн үйл ажиллагаа, барилгын түүхийн талаар 1 удаа, Unnu.mn сайтаас эрхлэн гаргаж буй анхны подкастад Улаанбаатар хотын түүх, түүх, архитектурын дурсгал болон музейн үйл ажиллагааны талаар 1 удаа, Ийгл телевизэд "Чойжин ламын сүм музейн цогцолбор” болон хотын соёлын өв, аялал жуулчлалын талаар 2 удаа, МҮОНТВ-ийн өглөө хөтөлбөрт Олон улсын музейн өдөр, Их хүрээний нүүдэл, Нийслэл хүрээний бүтэц, зохион байгуулалт болон Богдын хүрээний сүм хийдийн тухай 3 удаа, Монголын радиод Д.Манибадарын “Нийслэл хүрээ” зургийн түүх, дүрслэл, тус зурагт дүрслэгдсэн хуучин хотын бүтэц, зохион байгуулалт, хүн ам, түүхэн газарзүйн болон Улаанбаатар хотын сүлд тэмдэг Хангарди, “Нийслэл хүрээ” хөлөгт тоглоом, “Нийслэл хүрээ” хөлөгт тоглоомын тухай 4 удаагийн ярилцлага, Тэнгэр телевизэд Чойжин ламын сүм музейн талаар, news.mn сайтад Арслантай гүүр, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улаанбаатар хотын ой санамжийг хадгалж үлдэх талаар 2 удаа тус тус ярилцлага, мэдээлэл өгч хамтран ажилласан.<br>Тайлант хугацаанд давхардсан тоогоор 18 телевиз, сэтгүүл, сайтад 23 удаа ярилцлага өгч, хот байгуулалт, түүх, соёлын дурсгал, музейн үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл хүргэж, иргэдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулав.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.6.4 | Музейн цахим хуудас, веб сайтаар дамжуулан иргэдэд хотын түүхийн талаар танин мэдэхүйн мэдлэг олгох цуврал мэдээллүүдийг сонирхолтой хэлбэрээр хүргэнэ | - | Сурталчилсан дурсгалын тоо | - | 20 | Улаанбаатар хот дахь үл хөдлөх дурсгалуудын<br>1. Анхны холбооны байшин<br>2. Соёлын төв өргөө<br>3. МУИС<br>4. МУБИС<br>5. Төв номын сан<br>6. Их дэлгүүр<br>7. Засгийн газрын ордон<br>8. Улаанбаатар зочид буудал<br>9. Чинван Ханддоржийн Өргөө<br>10. Богд хааны ордон музей<br>11. Драмын театр<br>12. Дуурийн театр<br>13. Ард кино театр<br>14. Нэгдүгээр сургууль<br>15. Гандан<br>16. Гадаад харилцааны яам<br>17. Туул зоогийн газар<br>18. Занабазарын музей<br>19. Улаанбаатар хотын музей<br>20. Чойжин ламын музей зэрэг Улаанбаатар хотын үл хөдлөх түүх соёлын дурсгалт барилгуудын өнгөрсөн болон одоо үеийн гэрэл зургуудыг харьцуулсан байдлаар эвлүүлж товч түүхэн мэдээллийг “Улаанбаатар хотын тойрон аялал” ном болон www.ubheritage.mn сайтаас бэлтгэн музейн цахим хуудсанд нийтэлж олон нийтийн хүртээл болгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.7 | **Музейн цуглуулгын каталог, шинжлэх ухааны болон олон нийтэд зориулсан ном, хэвлэл бэлтгэн нийтэлнэ. /УБХМД-4.2.7/** | | | | | | |
| 4.7.1 | Улаанбаатар хотын түүхийн сэдэвтэй танин мэдэхүйн зурагт номын эхийг бэлтгэнэ. | 3,000 Нийслэлийн төсөв | Бэлтгэсэн эхийн тоо | - | 1 | Улаанбаатар хотын түүхийн сэдэвтэй танин мэдэхүйн зурагт номын эхийг бэлтгэх төсөл боловсруулж. “Эсгий хотоос өнөөгийн Улаанбаатар” сэдэвт танин мэдэхүйн зурагт номын эхийг “Urga book” компанитай хамтран музейн цуврал 3 дахь ном болгон гарахаар төслийг бэлтгэж, саналыг гаргаж “Urga book”-д хүргүүлсэн. Ерөнхий загвар нь PDF-р файлаар гарсан байгаа.<br>-Эх бэлтгэлийн 3,000 төгрөгийн төсвийн 495,000 төгрөг нь боловсролын дэд хөтөлбөрт зарцуулагдаж, үлдсэн 2,505,000 төгрөг нь хэмнэлтийн хуулиар зохицуулагдан буцаагдсан.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.7.2 | “Нийслэл хүрээ” зурагт номыг хэвлүүлнэ. | 3,720 Нийслэлийн төсөв | Хэвлүүлсэн номын тоо | 40 | 100 | Сэлэнгэ хэвлэлийн газартай гэрээ байгуулан “Нийслэл хүрээ зурагт номыг 150 ширхэг, нийслэл хүрээ сэдэвт даавуун тор 25 ширхэг, энгэрийн тэмдэг 30 ширхэгийг хэвлүүлэсэн.<br>-“Нийслэл хүрээ” зурагт номыг хэвлүүлэхэд шаардагдах 3,720,000 (гурван сая долоон зуун хорин мянга) төгрөгийг Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гаргав.<br>-150 ширхэг 'Нийслэл хүрээ' зурагт номыг 3,300,000төгрөг, 'Нийслэл хүрээ' сэдэвт 25 ширхэг даавуун торыг 330,000 төгрөг, 30 ширхэн энгэрийн тэмдгийг 90,000 төгрөгөөр нийт 3,720,000төгрөгт хэвлүүлсэн.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.7.3 | Музейн бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэдэд түүх, соёлыг сурталчлан таниулах зорилгоор “Социалист Улаанбаатар” хөлөгт тоглоомын эхийг бэлтгүүлнэ. | 1,280 Нийслэлийн төсөв | Эх бэлтгэлийн тоо | - | 1 | -“Социалист Улаанбаатар хөлөгт” тоглоомын эхийг бэлдүүлэх үнийн саналыг Сэлэнгэ хэвлэл, Соёмбо, Гама зэрэг газруудаас авч, музейн удирдлагад танилцуулж, Гама хэвлэлийн газраар эхийг бэлтгүүлэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөлөгт тоглоомын эх бэлтгэлийг батлагдсан төсөвийн дагуу 1,280,000 төгрөгийг Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гаргав.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.8 | **Соёлын биет өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн санг бүрдүүлж, Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд холбогдох мэдээллийг дамжуулна. /УБХМД-4.2.8/** | | | | | | |
| 4.8.1 | Музейн үзмэр, эд өлгийн зүйлтэй холбоотой 2022 оны үйл ажиллагаанд үүссэн баримт бичгийг Соёлын өвийг хамгаалах тухай хууль, архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу бүртгэл мэдээллийн санд бүрдүүлэлт хийнэ. | - | Бүрдүүлэлт хийсэн баримтын тоо | 3 | 4 | Байгууллагын бүртгэл мэдээллийн санд 2022 онд үүссэн үзмэр, эд өлгийн зүйлийн хөдөлгөөний акт болон бүртгэлттэй холбогдолтой дөрвөн төрлийн баримтаар бүртгэл мэдээллийн санд бүрдүүлэлт хийлээ. Үүнд:<br>1.2022 онд музейд шинээр авсан үзмэр, эд өлгийн зүйлийн холбогдолтой баримт<br>2.Үзмэрийн хөдөлгөөний холбогдолтой баримт<br>3.2022 оны байгууллагын сан хөмрөгийн тооллого явуулсан баримт<br>4.2022 бүртгэл мэдээллийн сангийн тайлан<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.06.31<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.8.2 | Музейн бүртгэл мэдээллийн сангийн тайланг батлагдсан маягтын дагуу гаргаж, Соёлын Өвийн Үндэсний төвд хүргүүлнэ. | - | Гаргасан тайлангийн тоо | - | 1 | Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл, мэдээллийн сангийн 2023 оны хагас жилийн тайланг ТСХДЗ-2.1, ТСХДЗ-2.2 маягтын дагуу гарган Соёлын Өвийн Үндэсний төвд хүргүүлсэн.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.06.31<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 4.9 | **Музей нь өөрийн цахим хуудастай байна. Цахим хуудсанд музейн эрхэм зорилго, байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, музейгээс зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэнгийн мэдээ мэдээлэл, санхүүжилт, төлбөр хураамж, санал, хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авч шийдвэрлэсэн дэлгэрэнгүй мэдээллийг байршуулан эргэх холбоог хангаж ажиллана. /УБХМД-4.2.8/** | | | | | | |
| 4.9.1 | Музейгээс зохион байгуулсан арга хэмжээнүүдийг байгууллагын олон нийтийн цахим сувгуудаар /инстаграм, фэйсбүүк/ дамжуулан олон нийтэд хүргэнэ. | - | Цахим хуудаст оруулсан мэдээллийн тоо | 50 | 60 | Дараах мэдээ мэдээллийг байгууллагын www.ubmuseum.mn цахим хуудсанд нийтэлсэн:<br>- “Соёлын сэргэлт-2023” аяны нээлт боллоо<br>-Улаанбаатар хотын музейгээс “соёлын сэргэлт” аяны хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны хөтөлбөр,<br>-Олон Улсын Музейн өдрийн нээлт “Чингис Хаан”үндэсний музейд боллоо<br>-Дотоодын цэргийн 805 дугаар ангийн офицер, хугацаат цэргийн алба хаагчид музей үзүүлэв | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Утаагүй тамхи мода биш” сэдэвт лекц зохион байгуулав,<br>-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарын шинэ оны мэндчилгээ, -Нийслэлийн хөдөлмөрийн аваргууд тодорлоо зэрэг 51 мэдээ, нийтлэл, www.erp.ulaanbaatar.mn хуудсанд:<br>- “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян"-д Улаанбаатар хотын музей нэгдэж байна,<br>-“Улаанбаатар хотын музейн ажилтнууд нийтийн эзэмшлийн гудамж талбайн цас цэвэрлэв”, "Хүүхэд нэгдүгээрт" аянд нэгдэж холбогдох постерийг хийж,<br>-“Хүүхдэд цаг гаргаж хайрыг түгээе” зэрэг 4 сэдэвт мэдээг нийтлүүлсэн. www.facebook.com/ulaanbaatarcitymuseum хуудсанд:<br>25 мэдээ, мэдээлэл тус тус нийтэлж дээрх сувгуудаар нийт 83 мэдээ, мэдээлэл нийтэлсэн.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 4.9.2 | Музейгээр үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлж, орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэн, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллана. | 3,780 Нийслэлийн төсөв | Төвлөрүүлсэн орлогын хэмжээ | 3,060 | 3,780 | Тайлант хугацаанд том хүний тасалбар 998 ширхэг, оюутны тасалбар 598 ширхэг нийт 3891 ширхэг тасалбар борлуулагдаж нийт орлого болох 3,891,000 төгрөгийг цаг хугацаанд нь төрийн сангийн дансанд төвлөрүүлэв.<br>Музейн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 3,780.0 мян.төгрөг<br>Гүйцэтгэл **3,891.5 мян.төгрөг,** орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.<br>"Музейн нээлттэй өдрүүд" арга хэмжээний үеийн үзэгч орлогын дүн1,107 мян.төг байна. Нийт үзэгчдэд үнэ төлбөргүй үйлчилсэн байдаг. | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td><table><tr><td></td><td>тоо</td><td>үнэ</td><td>Нийт</td></tr><tr><td>Том хүн</td><td>323</td><td>3,000</td><td>969,000.00</td></tr><tr><td>Оюутан</td><td>92</td><td>1,500</td><td>138,000.00</td></tr><tr><td></td><td></td><td></td><td>1,107,000.00</td></tr></table></td><td></td></tr>
<tr><td colspan="8">Зорилт 5. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт - Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай, хүртээмжтэй болгоход чиглэсэн зорилт. /Үүнд: албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, иргэд аж ахуйн нэгж байгууллагуудад шууд үзүүлж байгаа бүртгэл, нийгмийн халамж, нийгмийн даатгал, зөвшөөрөл/</td></tr>
<tr><td>5.1</td><td>Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх</td><td>-</td><td>Хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн хоногийн тоо</td><td>5</td><td>5</td><td>Тайлант хугацаанд иргэн Д.Мөнхтөмөр ажилд орох өргөдөл, хүсэлт гаргасан бөгөөд музейн захирлын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар туршилтын 3 сарын хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан жижүүрийн албан тушаалд ажиллуулж эхэлсэн.<br>2023 оны 06 дугаар сарын байдлаар музейд иргэд, албан хаагчдаас нийт нэг өргөдөл иргэн, албан хаагчдаас ирсэн бөгөөд өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 2 цаг 30 минут байна.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.06.31<br>Биелэлтийн хувь: 100%</td><td>100</td></tr>
<tr><td>5.2</td><td>Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийж, түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулах.</td><td>-</td><td>Боловсруулсан баримт бичгийн тоо</td><td>-</td><td>4</td><td>-“Музейн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа” шинэчлэн боловсруулах ажлын төлөвлөгөө, маягтыг музейн захирлаар 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр батлуулав.<br>Дүгнэлт<br>2023 оны 3 дугаар сарын 02-нд музейн үзэгчдээс байгууллагын үйл ажиллагааны талаарх санал хүсэлт бичүүлэх, бичигдсэн санал хүсэлтийг үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх ажилаа тусган ажиллах зорилгоор “Санал хүсэлтийн дэвтэр” бэлтгэн гаргасан.<br>Музейн тайлбарлагч Д.Дэлгэрмөрөн, үзмэр харагч Л.Одмаа нар энэхүү дэврийг хариуцан ажиллаж үзэгчдээс санал хүсэлт авсан.<br>Санал хүсэлтийн дэвтэр” -т нийт 43 үзэгч санал хүсэлтээ бичиж үлдээсэн байна.</td><td>100</td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үзэгчдийн бичсэн санал хүсэлтэд дүгнэлт хийж үзэхэд:<br>- Улсынхаа нийслэл хотын музейд зочлон төрөлх хотынхоо түүхтэй танилцсандаа сэтгэгдэл өндөр байгаа тухай<br>- Музей тайлбарлагчийн тайлбарт сэтгэл ханамжтай байгаа тухай<br>- Түүхэн ховор гэрэл зургууд, үзмэр үзсэндээ талархалтай байгаа тухай<br>- Музейн хамт олонд ажлын амжилт хүссэн тухай зэрэг эерэг сэтгэгдлүүд их байна.<br>Мөн музейгээ цаашид хөгжүүлж, өргөжүүлэх тухай санал хүсэлтүүд нилээд бичжээ. Үүнд:<br>- Үзүүллэгтийн танхим зай талбай маш муу<br>- Үзмэрээ баяжуулах<br>- Нийслэл хот санхүүжилт гарган музейгээ шинэчлэх<br>- Иргэдээс хандив цуглуулж музейн гадна хэсгийг засварлан будах<br>- Шинэ байртай болгох гэсэн сэтгэгдлүүд их бичсэн байна.<br>Үүнээс дүгнэн үзэхэд манай музей музейн барилга, үзүүллэгийн танхимд засвар, сэргээн засварлалт хийх, музейн өргөтгөл барих зэрэг тулгамдсан асуудлууд үүсээд байгааг дээрх үзэгчдийн сэтгэгдлээс бэлхнээ харж болохоор байна.<br>Музейн үзэчдэд "Санал хүсэлтийн дэвтэр" шинээр бэлтгэн гаргаж, "музейн үзэгчийн сэтгэл ханамжийн судалгаа" шинээр боловсруулан музейн захирлаар батлуулж улирал бүрийн эцэст бөглөсөн судалгаанд анализ хийн түүний мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулна. -"Санал хүсэлтийн дэвтэр" шинээр бэлтгэн гаргаж, санал хүсэлт авсаар байна. 2023.03.02<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 5.3 | Музейн үйлчлүүлэгчдэд хөнгөн шуурхай үйлчлэх үүднээс тасалбарын орлогыг хүлээж | 4,000 | Посын машины тоо | - | 1 | -Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх цахим дэлгүүрт байрших банкны төлбөрийн карт унших пос машин төхөөрөмжийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авах пос машины үнийн судалгаа хийж холбогдох мэргэжилтэнд хүргүүлнэ. | Нийслэлийн төсөв | | | | журмын дагуу гэрээ байгуулан, сангийн яаманд төхөөрөмжийн тохиргоо хийлгэж Музейн тасалбарыг төрөлжүүлж, бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслээр худалдан борлуулах боломжийг бүрдүүлж ажиллав.<br>Гэрээний дугаар:УБХМ/001/001<br>Барааны код:202204010_2<br>Барааны нэр: Пос төхөөрөмж<br>Тоо ширхэг:1<br>Үнэ:1,300,000 төгрөг<br>1жилийн үйлчилгээний хураамж:99,000төг<br>Пин карт:10,500 төгрөг<br>Эхлэсэн, дуусан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 5.4 | Музейн үйлчлүүлэгчид музейн үзүүллэгийн танхимд баримтлах дэгийг шинэчлэн боловсруулж, билет хэвлэх | 1,500 Нийслэлийн төсөв | Билетийн тоо | - | 1,000 | 9 дүгээр сард музейн үзэгчийн тасалбар шинээр хэвлэн гаргасан ба уг тасалбарын ард талд Музейн үйлчлүүлэгчид музейн үзүүллэгийн танхимд баримтлах 4 дэгийг зурган болон текст хэлбэрээр хэвлэн гаргасан.<br>Эхлэсэн, дуусан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 5.5 | Төсвийн хөрөнгөөр хийгдсэн судалгаа, шинжилгээ, ажлын тайлан, холбогдох бусад материалыг албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулах. | - | Байршуулсан мэдээллийн тоо | - | 1 | Нийслэл хүрээ зурагт ном, Улаанбаатар сонины эмхтгэл, Ломбардын бичиг гурван мэдээллийг www.sudalgaa.mn цахим хуудсанд нийтэд нээлттэй байршуулсан.<br>Эхлэсэн, дуусан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |
| 5.6 | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх. | - | Хуулийн дагуу хэрэгжүүлэх | Ил тод бүрэн мэдээллэх | Ил тод бүрэн мэдээллэх | -Музейн 2023 оны батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шилэн дансанд хугацаанд нь бүрэн байршуулсан.<br>-Музейн 1-4-р улирлын 5,0 саяас дээш орлого, зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд хугацаанд нь байршуулсан.<br>-Шилэн дансанд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ бусад өдөр тутмын мэдээ мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн байршуулсан.<br>Нийт 132 мэдээ, мэдээлэл хуулийн хугацаанд байршуулсан. Хугацаа хоцроосон мэдээ, мэдээлэл байхгүй. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | |
| 5.7 | Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх. | - | Байршуулсан бичиг баримтын тоо | - | 1 /аудитын дүгнэлт/ | 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлан, дүгнэлтийг бүрэн эхээр нь шилэн дансанд хуулийн хугацаанд ил тод байршуулсан.<br>Эхлэсэн, дууссан огноо: 2023.01.02-2023.12.11<br>Биелэлтийн хувь: 100% | 100 |

**6.** Нэмэлт ажлын хүрээнд:

| Д/д | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 6.1 | Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан “Улаанбаатарын өвлийн наадам” арга хэмжээг 2023 оны 02-р сарын 11-12-ний өдрүүдэд “Скайрезорт” цанын баазад зохион байгуулагдана. Наадмын үеэр иргэд, жуулчдын дунд зохион байгуулагдах тэмцээн уралдааны шагналыг өөрийн бүтээгдэхүүн, үзвэр үйлчилгээний эрхээр ивээн тэтгэж, байгууллагын үйл ажиллагаа бүтээгдэхүүнийг сурталчлан хамтран ажиллах. | Музейн захирал | Улаанбаатарын өвлийн наадам” арга хэмжээг 2023 оны 02-р сарын 11-12-ний өдрүүдэд “Скайрезорт” цанын баазад зохион байгуулагдсан үйл ажиллагаанд Улаанбаатар хотын музей нь ивээн тэтгэгчээр оролцож 5 гэр бүлийг үзвэрийн эрх болон 257,500 үнийн дүн бүхий бүтээгдэхүүнээр шагнан хамтран ажилласан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2023.02.11-2023.02.13<br>Биелэлтийн хувь: 100 хувь |
| 6.2 | -Байгууллагын 2023 оны 1-р улирлын тайлан нэгтгэн гаргаж НЗДТГ, НСУГ-т хүргүүлэв | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | Тус номд 457 түүхэн үйл явдлын бичвэр багтсанаас өмнөх хэвлэлтээс 308 бичвэрийг гол, туслах үйл явдлаар сонгож, 149 бичвэрийг гол, туслах үйл явдлаар шинээр нэмж бичсэн. Өмнөх хэвлэлтээс сонгогдон орсон 308 бичвэрээс 107 бичвэрийг шинэчлэн найруулж, 92 бичвэрийн мэдээллийг шинэчилж, нийт 199 бичвэрийг засварлаж, шинэчилсэн. 1912-1922 он буюу 111 жилийн хугацаанд хамаарах 1146 он тоолол (цагийн хүрд)-ын мэдээлэл номд орсноос 1086 мэдээллийг шинээр бичиж оруулсан. Мөн номд орсон нийт 111 гол үйл явдлын бүх гэрэл зургийн тайлбарыг бичиж, номд багтсан нийт гэрэл зургаас 80 гэрэл зургийг хувийн архив, гэрэл зурагчид болон архиваас авч шинээр нэмж оруулсан.<br>Үүнээс гадна номын техник хяналтын уншлагыг хийж, номд орсон бүх хүний нэр, хүний нэрийн овог, улс, хот, байгууллагын нэрийг түүхийн эх сурвалж, судалгааны бүтээлүүдтэй тулган үзэж алдаатайг засварлаж, зарим |

| | | | |
|---|---|---|---|
| | | | нэрүүдийг өдгөө хэвшсэн бичлэгээр бичсэн. Жишээ нь: Жавзандамба, Живзундамба гэж олон хэлбэрээр бичсэн нэрийг Живзүндамба гэсэн нэрээр жигдэлсэн. Мөн тоот тогтоол, дугаар захирамж гэж хоёр хэлбэрээр бичигдсэн бүх бичвэрийг дугаар гэсэн бичлэгийн хэлбэрээр жигдэлсэн. ЗХУ-БНМАУ, Дархан-Улаанбаатар гэх мэтээр бичигдсэн бүх нэр томъёог БНМАУ-ЗХУ, Улаанбаатар-Дархан гэсэн бичлэгтэй болгосон. Улаанбаатар хотын 360 жилийн ойг 36 жилийн ой, 14-р Далай ламыг 4-р лам гэж бичсэнийг залруулж, мөн он цаггүй, баримтын он зөрсөн мэдээллийг засаж залруулсан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2023.01.01-2023.06.30<br>Биелэлтийн хувь: 100 хувь |
| 6.3 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцоно. | Нийслэлийн Биеийн тамир спортын хороо | Нийслэлийн Биеийн тамир спортын хорооноос зохион байгуулсан "Цасны баяр"-ын үйл ажиллагаанд музейгээс нийт 11 албан хаагч оролцож, хамт олны дунд сумо, уулын оргил булаалдах тэмцээнийг зохион байгууллаа. 2023.02.11 |
| 6.4 | Нийслэлийн нийгмийн салбарын байгууллагуудын удирдлагуудын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн шуурхай хурлаар утаагүй тамхи татах нь мода (соёл) биш гэсэн утга агуулгатай хүүхэд, залуучуудад сурталчлан таниулах соён гэгээрлийн “Электрон тамхигүй-Эрүүл ирээдүй” нөлөөллийн аяны хүрээнд хамтран ажиллах | НЗДТГ<br>Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг аялал жуулчлалын газар | 2023.02.15-нд Манай байгууллагаас хүүхэд, залууст тамхины хор уршгийг сурталчлан таниулах “Электрон тамхигүй-Эрүүл ирээдүй” нөлөөллийн аяны хүрээнд дараах ажлыг хийж хамран ажиллах төлөвлөгөөгөө хүргүүлж, Баянзүрх дүүргийн 6, 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 21, 84 дүгээр сургуулийн 8-12 дугаар ангийн 300 сурагчдад “Электрон тамхи мода биш” сэдэвт лекц унших ажлыг нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулан ажилласан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2023.01.30-2023.02.15<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.5 | Байгууллагын хог ачилтыг хариуцан ажиллах | Менежер | 2023 оны 03 сарын 23-ны өдөр Баянзүрх дүүргийн хог ачилтын хэлтэстэй хамтран музейн гаднах хогийг ачуулж байгууллагын гаднах орчныг цэвэрлэв.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2023.03.27<br>Биелэлтийн хувь: 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 6.6 | Хотын аялал зохион байгуулах | Хамтын ажиллагааны хүрээнд | Гайд центр сургалтын төвд суралцагч хөтөч тайлбарлагчдыг дадлагажуулах "Улаанбаатар хоттой танилцах хот болон хот орчмын аялал"-д хөтөчөөр ажиллаж, хотын түүх болон соёлын өвийн талаар тайлбар хийв. Тус аялалд нийт 35 хөтөч тайлбарлагч хамрагдав.<br>Гэр өргөө ТББ-аас зохион байгуулж буй "Хөрөг бичээч" хөтөлбөрт хамрагдаж буй 12 залуусыг 2023.06.11-нд "Улаанбаатар хотын 220, 34-р хороололтой танилцах аялал"-д хамруулж, хотын ерөнхий түүх, орон сууцны хорооллын түүх, тус хорооллын орчим дахь соёлын өв, гудамж, түүхэн орон зай, шилжилт хөдөлгөөний түүхийн талаар ярьж тайлбарлав.<br>Хотын 2 удаагийн аялалд нийт 47 хүн хамрагдав. |
| 6.7 | Гоожингийн өндөр)-ыг музейн чиглэлээр ажиллуулах бэлтгэл ажлын хүрээнд хийсэн ажлын тайланг бичиж хүргүүлэх | Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газраас ирсэн албан бичиг | Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/1032 дугаартай захирамжийн 2.2 түүх соёлын үл хөдлөх дурсгалт газрыг музейн чиглэлээр ажиллуулах бэлтгэл ажлыг 2022 оны IV улиралд багтаан хангахыг "Улаанбаатар хотын музей" НҮТГ (П.Даваасүрэн)-т даалгасан байна. Иймд тус асуудлаар санал, дүгнэлт өгч, даалгасан арга хэмжээний хүрээнд Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газраас 2023.04.14-ний өдрийн 4/742 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/032 дугаар захирамжаар музейд үүрэг болгосон ажлын тайланг явуулж хамтран ажиллахыг хүссэн. Энэхүү албан бичгийн дагуу Ерөнхий сайд Т.Намнансүрэнгийн амьдарч байсан 2 давхар барилга (Гоожингийн өндөр)-ыг музейн чиглэлээр ажиллуулах бэлтгэл ажлын хүрээнд хийсэн ажлын тайланг бичиж хүргүүлсэн. |
| 6.8 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцоно. | Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны А/01 дүгээр тушаалаар баталсан их цэвэрлэгээг хуваарийн дагуу музейн нийт албан хаагчид хийсэн ба тухай бүрт тайланг илгээсэн.<br>1."Ердөө 90 минут" их цэвэрлэгээний удирдамжийн дагуу байгууллагын гаднах орчны 50 метр хүртэлх зам талбайн хог, хаягдал, цас мөсийг цэвэрлэсэн. 2023.01.13 |

| | | | |
|---|---|---|---|
| | | | 2. Сар шинийн баярыг угтсан “Хоггүй шинэлье” бүх нийтийн их цэвэрлэгээний удирдамжийн дагуу байгууллагын гаднах орчны 50 метр хүртлэх зам талбайн хог, хаягдал, цас мөсийг цэвэрлэсэн. 2023.02.17<br>3.“Хаврын их цэвэрлэгээ”-ний удирдамжийн дагуу Туул гол, далангийн хог, хаягдлыг цэвэрлэж шуудайлан хогийн цэгт төвлөрүүлсэн. 2023.04.14<br>4. “Хотооугаая их цэвэрлэгээ”-ний удирдамжийн дагуу байгууллагын хашаанд болон гаднах орчны 50 метр хүртлэх зам талбайн хог, хаягдлыг цэвэрлэсэн. 2023.05.26<br>Эхэлсэн, дууссан огноо: 2023.01.13-05.26<br>Биелэлтийн хувь: 100% |
| 6.9 | Соёлын салбарын байгуулагуудын биеийн тамир, уралдаан тэмцээнд идэвхтэй оролцох. | НСУГ | Нийслэлийн соёл урлагийн газрын харъяа байгууллагуудын уламжлалт тэмцээний дартс, ширээний теннис, бильярдын төрлүүдэд тус байгууллагын 7 тамирчин амжилттай оролцлоо.<br>Эхэлсэн, дууссан огноо: 2023. 01.13-05.26<br>Биелэлтийн хувь: 100% |

Тайлбар: 2023 онд Улаанбаатар хотын музей нь үндсэн чиг үүргийн 42, хуулиар хүлээсэн чиг үүргийн 21, нийт 63 арга хэмжээ хэрэгжүүлснээс 61 арга хэмжээ нь 100 хувийн биелэлттэй, 1 арга хэмжээ 50 хувийн биелэлттэй, 1 арга хэмжээ 80 хувийн биелэлттэй хийгдэж нийт дүнгээр **98.88%-ийн** биелэлттэйгээр гүйцэтгэсэн байна.

*Төлөвлөгөөг хянасан:*
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ ......................... **_Төсвийн Ерөнхийлөн захирагч_** (Х.Нямбаатар)

*2023 оны . . . сарын . . . өдөр*

*Төлөвлөгөөг тайлагнасан:*
УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН
ЗАХИРАЛ ......................... **_Төсвийн Шууд захирагч_** (П.Даваасүрэн)

*2023 оны . . . сарын . . . өдөр*